

Монгол ярианы бүтцийн хэв шинжүүд

Равдан Э.
/МУИС/

1. Ерөнхий ойлголт

Аливаа хэл аман хийгээд бичгийн гэсэн хоёр хэлбэрээр нийгэмд үйлчилдэг. Хэлэхүйн аман хэлбэрийг **ярианы**, бичгийнхийг нь **утгазохиолын хэл** гэж нэрлэн тэдгээрийг хэл шинжлэлд 20-р зууны дунд үеэс зааглаж ирсэн байна. Хэдийвээр “хэл” хэмээн нэрлэх нь болзмол чанартай боловч хэлний хийгээд түүний хэрэглээтэй холбоотой нарийн учир шалтгаан энд бий. Энэ нь юуны өмнө хүмүүний хэл ярианы зорилго, хэлний хэрэглэхүүнийг хэрэглэх хүрээ, сэдэв зэрэг хэлний бус олон хүчин зүйлээс шалтгаалан нийгмийн амьдралын тодорхой орчинд бүх нийтийн хэлний өчүүхэн хэсэг байнгын хэрэглээнд хэвшин эргэлдэж түүнийг дагасан хэлний **хэм хэмжээ** (хэлний хэрэглэхүүнийг хэрэглэх бүх нийтийн хүлээн зөвшөөрч даган мөрддөг дүрэм журмын цогц) бүрэлдэн тогтдог явдалд оршино. Тэгэхээр хэлний **ярианы** хэлбэр буюу энгийн яриа гэж нийгмийн ахуйн харилцаанд, тухайлбал гэр орон, дэлгүүр хоршоо, нийтийн унаа гэх мэт амьдрал ахуйн хамгийн наад захын хүрээнд бие биетэйгээ хүмүүсийн харилцах хэрэгцээг хангадаг хэлэхүйн нэгэн төрлийг бид хэлж байна.

Нөгөөтэйгүүр, энгийн ярианы тухай өгүүлэхдээ орчин үеийн үүргийн буюу функциональ хэл шинжлэлийн үүднээс хэм хэмжээний тухай ойлголтыг хэл ярианы орчин, хэлэхүйн төрөл, ярилцагч хүмүүсийн нас, хүйс, ажил төрөл, боловсрол зэргийн ялгаа гэх мэт нийгмийн олон хүчин зүйлтэй холбон ойлгож түүнд уян хатан байдлаар хандууштай. Судалгаанд хэлний функциональ зарчмын, эсхүл энгийнээр хэлбэл харилцагч хүний санаагаа илэрхийлэх зорилгын үүднээс хандвал энгийн ярианы хэлийг “хар”, “тулга тойрсон хэдэн үг” гэж гоочлон хоёрдугаарт үзэх, утгазохиолын буюу бичгийн хэлбэрийг нь гойдлон тусгаарлах, эсхүл бичгийн хэлний хэм хэмжээг энгийн ярианы хэлбэрт тулган “сайжруулах” гэж оролдон хүч хэрэглэх зэрэг олон сөрөг үзэгдэл гарах үүд хаалга хаагдах юм. Жишээлбэл, энгийн ярианы *ш дээ - шүү дээ; гэхийм - гэх юм*, эсхүл *автуус - атуус - автбуус - автабуус* гэх мэт дуудлагын олон төрлийг зааглан үзэхдээ юуг, хэн, хаана, хэзээ хэрэглэж байгаагаас шалтгаалан ялгаа заагтай үзэх шаардлагатай. Энэ ч үүднээс тодорхой хэлээр ярилцагч хүмүүсийн хэл ярианы соёлыг дээшлүүлэх зорилгоор хэл ярианы шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөмж боловсруулах, нөгөөтэйгүүр тэрхүү аялгуунд гадаадын иргэдийг сургах үйлд

дээрх зарчмыг туйлбартай баримтлах учиртай болно. Өөрөөр хэлбэл, хэл ярианы хэм хэмжээг хаана, хэнтэй, юуны тухай, ямар нөхцөл буюу орчинд ярьж байгаа зэргээс үүдэн ялгавартай хандах хэрэгтэй болохоос биш “утгазохиолын” хэмээсэн ганц хувилбар тулган шахах нь зүй бус болохыг дээрх жишээгээр батлахыг оролдов.

Хэлэхүйн аливаа төрөл, түүний дотор энгийн яриаг ч хэлний түвшин (авиазүй, үгзүй, өгүүлбэрзүй, үгийн сан г.м.) бүрээр судлах шаардлага урган гардаг. Эдүгээ тооцоолон бодох машинтай буюу орчин үеийн цахимтай харилцаа ярианы хэлбэрээр харилцах тухай асуудал аль хэдийнээ тавигдаад төлөвших шатандаа ороод байна. Тийм төрлийн судалгааг дэлхийн олон хэлэнд аль хэдийнээ хийгээд эхэлчихжээ.¹

Түүний наад захын жишээ нь эдүгээ өгүүлэгч хүний дуу хоолой, аялга дуудлагаар нь мэдэрдэг цахимын программ хэрэглээнд орж цахимд “шивэх” үйлээс хүмүүсийг чөлөөлж байна. Энгийн ярианы авиазүй, үгзүй, өгүүлбэрзүй гэх мэтээр өгүүлэх нь хэвийн үзэгдэл нэгэнт болжээ. Функциональ судалгааны үр дүн, дүгнэлтүүд нь монгол хэл ярианы соёлыг дээшлүүлэх, монгол хэлийг гадны хүнд заах арга, аргачиллыг боловсруулах, харь хэлнээс монголчлох, харь хэлэнд хөрвүүлэх зэрэг олон үйлийн хэл шинжлэлийн үндэслэлийг боловсруулахад чухал ач холбогдолтой болно.

Одоо эл том цогцолбор судлалын нэгээхэн хэсэг - монгол энгийн ярианы өгүүлбэрзүйн асуудлын нэгэн талст болсон нэр бүтцийн тухай хөндөн өгүүлье.²

Энгийн хэл ярианы түгээмэл үзэгдэл нь түүний үүдэн гарсан хэлний бус хүчин зүйлтэй салшгүй холбоотой. Тэдгээрээс гол нь:

- **Нийт хүмүүний сэтгэн бодох хэвшмэл загвар.** Сэтгэн бодохын үр буюу бодот илрэл нь хэл яриа маргашгүй мөн. Хэл яриа үүсэх асуудлыг орчин үеийн сэтгэц хэл шинжлэлийн үүднээс хоёр чиглэлээр шийдвэрлэж байна.

Нэг чиглэл нь хэл яриаг хүмүүний олон үйлийн нэгэн хийсвэр хэлбэр болгон түүнд логик буюу учир шалтгааны үүднээс хандахыг чухалчилдаг. Эл үзэл баримтлалыг бүхэлд нь Оросын сэтгэц хэл шинжлэлийн чиглэл гэж нэрлэж болно. Эхлээд Л.С. Выготский, дараа нь А.Н. Леонтьев нарын боловсруулсан аливаа үйлийн онолоос үүдэн хэл яриа үүсэх онолын ерөнхий загварыг А.А. Леонтьев, Т.В. Ахутина нар, хэл яриаг хүлээн авах үйлийг И.А. Зимняя; хэл ярианд өндөр магадлалтай хэрэглэгддэг бүтцийн судалгааг Р.М. Фрумкина; үгээс ургуулан бодох холбоог А.П. Клименко, А.А. Залевская нар; бага насны хүүхдийн хэл ярианы хөгжлийг А.М. Шахнарович нар; бичвэрийн сэтгэц хэл шинжлэлийн талыг Т.М. Дридзе нар тус тус хөгжүүлсэн байна.

¹ Э. Равдан, Ж. Пүрэв. Тав дахь үеийн цахимын хувьсгалаас үүдсэн монгол хэл-соёлын тухай бодрол- “Гадаад хэл заах аргазүйн асуудал”, 2006, 1 9. 28- 29-р тал

² Энд орсон нийт жишээг хэдэн жилийн өмнө “ Монгол энгийн аман яриа” сэдэвт эрдэм шинжилгээний төслийн хүрээнд соронзон хальсанд буулгасан материалаас бид ашигласан болно. Бичлэгийг хот, хөдөөгийн янз бүрийн насны, эрэгтэй, эмэгтэй, боловсрол, ажил мэргэжлийн хувьд өөр өөр олон хүний төрөл бүрийн сэдвээр ярьсан ярианаас үйлдсэн болно.

Нөгөө чиглэлд нь хэл яриа бүтэх, түүнийг ойлгох үйл нь өөр хоорондоо шүтэлцээтэй нэгдмэл чанар бүхий үйл хэмээн үзэж тэдгээрийг хэлэх-сонсох эрхтэн, авиазүй, авиалбарзүй, үгийн сан-өгүүлбэрзүй, утгазүйн түвшинд алгоритм буюу шийдэл гаргах тодорхой дараалал бүхий үйлдлээр тогтоохыг зорьдог судлаачид хамаарна. Тийм учраас хэл ярианы алдаа, оюуны үгийн сан, бичвэрийн үгзүйн зохион байгуулалт, өгүүлбэрийн бүтцийн олон утга зэргийг юуны өмнө анхаардаг ажээ. Энэ чиглэлийг АНУ-ын сэтгэц хэл шинжээчдийн чиглэл гэж нэрлэж болно.

Хэл ярианы үүсэл, түүнийг ойлгох үйлийг алгоритмийн аргаар салиш, англи, хинди гэр билийн бага насны хүүхдүүд дээр J. F. Werker, R. C. Taas (Cross – Language Speech Perception: Evidence for Perceptual Reorganization During the First Year of Life.- Infant Behavior and Development 7: 49-63) нар туршилт тавьж баталжээ. Үгийн сан-өгүүлбэрзүй-утгазүйн шатанд хэл яриаг ойлгох үйлийг Yoppen (Warren, R. M. Perceptual Restoration of Missing Speech Sounds. Science 167: 392- 393) туршилтаар судалсан байна.

Хэл ярианы алдааны гол хэв шинж болсон зогсоц (pauses), эргэлзээ (hesitations), алдаагаа засах (corrections), аль нэг нэгжийг давтах (repetitions), өөр нэгжээр солих (substitutions), үг нэмэх , хэл хальтрах (slips of-the tongue) зэргийг F. Goldman-Eisler судалжээ. Тэрбээр 1968 онд явуулсан судалгаандаа (Psycholinguistics: Experiments in Spontaneous Speech. N.Y.: Acad. Press) хэл ярианы гуравны хоёр нь дундаар 6-гээс хэтрэхгүй урттай бөгөөд ерийн урсгал ярианд гардаг зогсоцын 55 % нь хэлзүйн бйрэлдййлбэрийн заагийг тогтоох зориулалттай болохыг тогтоосон байна.

Оюуны йгийн сангийн (mental lexicon) салбарт туршилт судалгааны дийлэнх нь йгийг харж таних ййлд чиглэжээ. Энд дараах судлаачдыг нэрлэж болно. Үүнд: Мортон (Morton, J., Word Recognition.- Morton, J., J.C. Marshall (eds). Psycholinguistics 2: Structure and Process. Cambridge (Mass.): MIT Press), С. Лима (Lima, S.D., Morphological Analyses in Sentence Reading – Journal of Memory and Language 26: 84-99), С. Эндрюс (Andrews, S., Morphological Influences on Lexical Access: Lexical or Nonlexical Effects. – Journal of Memory and Language 25: 100-138) Л. Фразер (Frazier, L., Against Lexical Generation of Syntx. – Marslen-Wilson, W. (ed.) Lexical Representation and Process. Cambridge (Mass.): MIT Press) Tyler, L., The Role of Lexical Representations in Language Comprehension. – Marslen-Wilson, W. (ed.) Lexical Representation and Process. Cambridge (Mass.): MIT Press), Tannenhaus, Carlson (Tannenhaus, M., G. Carlson. Lexical Structure and Language Comprehension. – Marslen-Wilson, W. (ed.) Lexical Representation and Process. Cambridge (Mass.): MIT Press) нар болно.³

- **Санаа бодлоо илэрхийлдэг хүмүүний түгээмэл уламжлал.** Энгийн яриа ил, шугаман байдлаар бодотойгоор оршин нийгмийн тодорхой хүрээнд хүмүүсийн харилцах хэрэгцээг ханган үйлчилдэг. Эл явцад хүмүүсийн илэрхийлж буй мэдээллийн төвүүд цаг ба орон зайн хувьд бие биеэс салан, тусгаар болж, бие даасан шинжтэй болоход аль болохоор тэмүүлэх нь олон хэл аялгуунд түгээмэл шинжтэй ажээ. Цөм утга хэлзүйн хувьд ингэж хэсэг бүлэг болж задрах үзэгдэл нь өгүүлэгч этгээд өөрийн

³ Энэ тухай Э.Равдан. Орчин цагийн хэл шинжлэл (суурь ба хавсарга чиглэл) (УБ. 2005) номын “Сэтгэц хэл шинжлэл” бөлгөөс дэлгэрэнгүй уншиж болно.)

санааг сонсогч хүнд илүү төхөмтэй, хялбар хүргэх зорилгоос үүдэлтэй. Мөн эл шалтгаанаар мэдээллийн хамгийн чухал тулгар хэсэг (онцолбор) урагш дэвшигдэн давын өмнө гол төлөв хэлэгдэх явдал түгээмэл, зарчмын шинжтэй болохыг олон хэлний энэ талын судалгаа тодорхой харуулж байна. Харилцааны эл логик зарчим аль ч хэлний аман ярианд үгийн байршлыг тодорхойлдог чухал хүчин зүйл болдог. (П. Адамес, К. Гаузенблас , О. Лаптева нарын судалгаа бэлхэнээ харуулж байна.) Энд юуны өмнө утгын цөмийг эрхэмлэх буюу хэмнэх үзэгдэл (*-Хэзээ явах вэ, та? - Маргааш*), түүнээс үүдэн цөм утга илэрхийлсэн үг, хэллэгийг бусад гишүүдээс аялга болон байрлалаар нь ялгах, үг хураах, үеэр эвхэх, хоёр-гурван бүтээврийг нийлүүлэх, авиа сугарах (*авч ирэх - авчрах (ацрах, ачрах), шүү дээ - шдээ, тийм ээ - т' ээ*) зэрэг үзэгдэл гардаг байна. Энгийн аман ярианд өгүүлбэрийн гишүүдийн тоо бичгийн хэлбэртэй зэрэгцүүлэхэд бараг хоёр дахин цөөн байдаг зэрэг болно.

Өгүүлэмж ⁴ (цогцолбор) хэлзүйн хувьд өгүүлбэрээр хэлбэржсэн нэгжүүдэд задрахдаа логикийн бие даасан онох (лат.subjectum, S) , оногдохуйн (лат. objectum, O) хоёр бүлэгт хуваагдах нь олон хэлний түгээмэл үзэгдэл бололтой. (Түүнийг олон хэлний материал дээр цааш судлан баталгаажуулах шаардлагатай.) Тийнхүү ($S \leftrightarrow P \leftrightarrow O$) логикийн нэгдлээс өгүүлбэрзүйн хувьд бие даасан нэгж болон задарсан нэрийн бүлэг S, O, тэдгээрийг илэрхийлсэн өгүүлбэрийг бид хэлбэр-утгазүйн үүднээс **нэр бүтэц** хэмээн томъёолж байна. Нэр бүтэц нь аялга болон хэлбэрийн хувьд гол төлөв энгийн өгүүлбэрийн шинжтэй байна. Нөгөөтэйгүүр, нэр бүтэц хэмээн үзэхийн үндэслэл нь өгүүлэмжийн утгын нэгдэл, түүнийг бүрэлдүүлсэн өгүүлбэр хоорондын утгын зохицол болно. Жишээлбэл, онохуйн (S) үүрэг гүйцэтгэж байгаа нэр бүтцээр илэрсэн өгүүлбэрийн утгын баталгаа нь түүний удаах өгүүлбэр эзэн биегүй энгийн өгүүлбэр байх жишээтэй. Оногдохуйн (O) үүргээр өгүүлбэр хэрэглэгдэж байна гэж үзэхийн үндэслэл нь нөгөө өгүүлбэрт туслах аль нэг гишүүн, тухайлбал тусагдахуун, төрөл бүрийн байц дутуу байх зэрэг болно. Жишээг хойноос үзнэ үү. Өгүүлэмж задарч нэр бүтцээр илэрсэн өгүүлбэрүүдийн бие даасан чанар олон тохиолдолд өвөрмөц аялга, зогсоц болон оруулсан үг хэллэг, сул үг, холбоос үг, төлөөний хийгээд дайвар үг, яриа хөгжүүлсэн үг хэллэг зэргээр давхар илрэх нь бий. Тэдгээрийг хойно өгсөн олон жишээнээс мөн үзнэ үү.

2. Нэр бүтцийн загвар, түүний хувилбарууд

Нэр бүтцээр илэрсэн өгүүлбэр дараах шинж тэмдгийг агуулсан байна. Үүнд:

- 1) Тодорхой санаа илэрхийлсэн өгүүлэмжээс үүдэлтэй байна. Хэлзүй болон аялга дуудлагын хувьд бие даасан өгүүлбэрийн шинжийг хадгалсан байна;
- 2) Утгын хувьд бие даан тусгаарласан нэрийн хэсэг нь өгүүлэмжийн нөгөө бүрэлдэхүүнд хэлбэр хийгээд утгын хувьд давхардах ёсгүй бөгөөд олон баримтаас харахад хэлбэр утгын хэлний хэмнэх зарчмын дагуу “дутуу” байна. Тийм учраас уламжлалт өгүүлбэрзүйн үүднээс авч

⁴ Өгүүлэмж гэж хэлбэрийн хувьд хэд хэдэн өгүүлбэрээс бүтсэн цогц санаа илэрхийлсэн өгүүлбэрийн дээд нэгжийг хэлнэ. Өгүүлэмжийн тухай Э. Равдан, Бүтэц хэл шинжлэл, УБ., 2002 номоос дэлгэрэнгүй үзнэ үү.

үзвэл нэр бүтцээр илэрсэн энгийн өгүүлбэр нь бүхэлдээ өгүүлэгдэхүүн эсвэл өгүүлэхүүн болохоор байна.

- 3) Нэр бүтцээр илэрсэн өгүүлбэр нь логикийн онохуй, оногдохуйн үүргээр зөвхөн хэрэглэгдэнэ.

Тийм учраас нэр бүтцээр илэрсэн өгүүлбэр бүхий өгүүлэмжийн ерөнхий бүтцэд хоёр бүрэлдэхүүнт энгийн өгүүлбэрийн бүдүүвчээс үүдсэн дөрвөн боломжийн :

- нэг өгүүлэгдэхүүн - нэг өгүүлэхүүн
- хоёр өгүүлэгдэхүүн- хоёр өгүүлэхүүн
- хоёр өгүүлэгдэхүүн - нэг өгүүлэхүүн
- нэг өгүүлэгдэхүүн - хоёр өгүүлэхүүний

аль аль нь ч хэрэгжсэн байж болно. Харин онох хийгээд оногдохуйн байрлал, дан болон харилцаа ярианд хэрэглэгдэх байдал нь санаагаа илэрхийлсэн өгүүлэгч хүний утгын загвараас шалтгаална. Өөрөөр хэлбэл, мэдээллийн суурь (хуучин), тулгар (шинэ) цогц энд чухал үүрэгтэй.

Нэр бүтцээр илэрсэн өгүүлбэрт үйл үг оролцсон эсэх, дэлгэрэнгүй ба дэлгэрэнгүй бус бүрэлдэхүүн, өгүүлэмж бүрэлдүүлсэн бусад өгүүлбэрийн өгүүлэхүүний бүтэц, бүрэлдэхүүн, үйл үгийн хэлзүйн олон утга, өгүүлэгдэхүүний төрөл бүрийн илэрхийлэл нь төлөөний нэр хэрэглэгдсэн эсэх, аялга, зогсоц зэргээс шалтгаалсан олон хувилбартай байж болно. Тэдгээрийг доор тус бүрээр нь олон жишээгээр дэлгэрэнгүй авч үзье.

А. Онохуйн (О) үүргээр хэрэглэгдсэн нэр бүтцийн бүлэг хувилбар.

Эл бүлэг хувилбарууд дараахь давхар шинж тэмдгийг агуулсан байна.Үүнд:

- 1) Нэр бүтцийн бүрэлдэхүүн онохын үүргийг гүйцэтгэсэн байна.
- 2) Нэр бүтцээр илэрсэн өгүүлбэр нь тухайн өгүүлэмжийн утгын цөм буюу тулгар мэдээлэл болох тохиолдолд өгүүлэмжийн эхэнд, өөрөөр хэлбэл онохуйн байршилд гол төлөв хэрэглэгдэнэ. Эл тохиолдолд өгүүлэмжийн бусад хэсгүүд уг онохуйг утгын хувьд тодотгон түүнд хэлбэр хийгээд утгын хувьд дам захирагдсан байна.
- 3) Нэр бүтэц дэлгэрэнгүй өгүүлбэрийн бүрэлдэхүүнтэй байж болно.
- 4) Нэр бүтцийг тодотгох үүрэг бүхий өгүүлбэр нь гол төлөв хэлзүйн эзэн биегүй бүтэцтэй байна.
- 5) Онохуйг тодотгох үүрэг бүхий өгүүлбэр нэр бүтцийн утга болон хэлбэрийн харьцаанд уламжлалт өгүүлбэрзүйн ойлголтоор бүхэлдээ өгүүлэхүүн гишүүний үүргийг хүлээсэн байна.

Дээрх шинж тэмдгүүд нь өгүүлэмжийн хүрээнд онохуйн үүрэгтэй нэр бүтцээр илэрсэн өгүүлбэрийн хувьд зарчмын шинжтэй. Гэхдээ энэ нь өмнө тэмдэглэснээр бүтцийн олон хувилбарыг хаах үндэслэл болохгүй. Одоо өгүүлэмжид онохуйн үүрэг хүлээсэн нэр бүтцийн хувилбар, түүний дэд хувилбар бүрийг нарийвчлан авч үзье.

Хувилбар 1. Эл хувилбар орчин цагийн монгол энгийн аман ярианд олонтаа тааралддаг тул түгээмэл шинжтэй. Нэр бүтцээр илэрхийлж байгаа уг юм, үзэгдэл яригч хүмүүсийн дэргэд, нүдэнд ил байх тохиолдол бүрт нэр бүтцийн аль ч хэсэгт биеийн төлөөний нэр хэрэглэх шаардлага тэр бүр гарахгүй. Хэлбэрийн хувьд гол төлөв харилцаа ярианы хэлбэрээр биш, дан ярианд хэрэглэгдэх өвөрмөц онцлогтой. Одоо эл хэв шинж бүхий бүтцүүдийг хэлбэр-утгазүйн үүднээс нь хувилбаруудад хуваан нарийвчлан авч үзье. Түүний тул нэрийн бүлэг буюу нэршсэн өгүүлбэрийг N., эзэн биегүй, өгүүлэхүүн нь үйл үгээр илэрсэн өгүүлбэрийг V., утгын харьяалагдах байдлыг сумаар зааж томъёолъё. Үүнд:

1) а. N. ← N.

*Ноён Хачимура. "Жайка" компанийн биет төлөөлөгч.
Доржийн хулгар хээр. Сайхан амьтан шүү.*

б. N. ← N.
← N.

*Итали гутал. Сайхан эд. Гол нь үнэ нь хямд.
Мөн сайхан аа. Өнгий нь ! Бас хээ нь.*

Эл дэд хувилбарт нэршсэн онохуйг тодотгох үүрэг бүхий өгүүлэмжийн бусад хэсгүүд тэгш эрхтэйгээр зэрэгцэн оржээ. Утгын хувьд уг онохуйн шинж тэмдгийг илэрхийлсэн байна. Зарчмын хувьд тодотгол өгүүлбэрүүдийг цааш үргэлжлүүлэх боломжтой боловч хоёроос илүү тодотгол өгүүлбэр хэлбэр хэрэглэгдэх нь баримтаас үзэхэд ховор бололтой. Одоо үйлийн үг оролцсон өгүүлэмжийг авч үзье.

2) а. N. ← V.

*Миний ах. Өчигдөр хөдөөнөөс ирсэн юм.
Нөгөө ном чинь. Өчигдөр шуудангаар ирж.*

Эл бүлэг жишээг дараах бүлэг жишээтэй зэрэгцүүлж үзнэ үү. Онохуйн үүргийг хүлээсэн нэр бүтцээр илэрсэн дээрх бүтцийг * тэмдэглэсэн оногдохуйн үүрэг хүлээсэн нэр бүтэцтэй хольж болохгүй. Доор өгсөн гурав дахь жишээ нь холимог шинжтэй байна⁵. Өгүүлэмжийн хоёр дахь өгүүлбэр нь онохуйн үүрэг хүлээсэн нэгдүгээр өгүүлбэрийг утга хийгээд хэлбэрийн хувьд нотолж байгаа бол нэгдүгээр өгүүлбэр нь гуравдугаар өгүүлбэрийн хувьд оногдохуйн үүргийг хүлээсэн байна.

**(Май,) Тахиа. Сайхан шөл хийгээрэй. ;*

**"Алтан тарианы" гурил. Өнөөдөр нэг сайхан бууз хийж идэцгээе. ;*

"Птичье молоко". Ёстой ховорхон чихэр шүү. Нөгөө зочноо ирэхээр өгөөрэй. ;

**(Нөгөө) өмд чинь. Товч нь хаягдчихсан.*

⁵ Нэр бүтцийн холимог хэлбэр төрөл зүйлийн хувьд маш олон янз тул энд энэ удаа оруулалгүй орхив.

Үйлийн үг оролцсон тодотгол өгүүлбэр нь үүргийн болоод утгын хувьд өмнө бидний авсан нэршсэн тодотгол өгүүлбэр оролцсон өгүүлэмжийн бүтцээс гойд ялгаагүй байна. Эл хоёр дэд хувилбарын түгээмэл утга нь тодорхой онохуйг таниулж тодотгосон байна. 2а хувилбар нөгөөтэйгүүр асуух өгүүлбэрт таарах нь цөөнгүй.

Аймгийн зам. Хаанаас салдаг юм бэ?

Хөөе, Доржийн уут. Аль нь юм бэ?

3. Нэршсэн болон үйлийн үг оролцсон өгүүлбэр хавсран тодотгосон 1.2 хувилбарын холимог хувилбар ажиглагдах нь цөөнгүй байна. Харин тодотгох чанар нь бидний ажигласнаар 1б хувилбараас бага зэргийн ялгаатай.

а. (N. ← N.) ← V.

Таны цалин . 50000 төгрөг. Өчигдөр буусан юм.

(50000 төгрөг. Таны цалин)Өчигдөр буусан юм.

б. (N. ← V.) ← V.

Нөгөө Сангийн аж ахуйн бүдүүн авгай. Яагаав дээ биднийг загнадаг.

(Мань хүн) өчигдөр ирчихсэн, энд тууж явдаг байгаа.

4. 1, 2 -р хувилбарууд харилцаа ярианы хэлбэрт шилжин хэрэглэгдэх нь мөн ажиглагдаж байна. Тэдгээр нь гол төлөв асуух, лавлах, таамаглах зэрэг утга бүхий өгүүлбэрээр харилцагч хүний зүгээс тасалдсан байх нь элбэг. Бусад хэсгүүд нь дээрх хувилбаруудтай зарчмын хувьд дүйнэ. Үүнд:

- N.

- ?

- N. (V.)

- *Нөгөө Дулмаа чинь !*

- *Яасан ?*

- *Аль өчигдөр арилаад өгсөн байна ш дээ.;*

- *Манай айлын энэ өвгөн (-ийг), чи яасан гэж санана.*

- *Яагаав? Явахгүй гээд суучихсан у?.*

- *Үгэй, хүн амьтан босоогүй байхад, биднийг хаяад ганцаараа явчихсан гээд л бод доо.*

5. Түүнчлэн 1, 2 – р хувилбарын бүрэлдүүлбэрүүдэд харилцагчийн анхаарлыг татах зорилго бүхий хандсан үг, хэллэг, ярьж байгаа зүйлд өгсөн өгүүлэгчийн үнэлгээг илэрхийлсэн төрөл бүрийн баймж бүхий оруулбар хэрэглэгдсэн байх нь мөн нэлээд түгээмэл байна. Үүнд:

Чи сонс. Энэ манай хөрш. Ер нь тун гайгүй хүн дэг ээ.;

*За байз, танай охин чинь, ингэхэд юусан билээ, түүхч гэл үү?;
Манай нөгөө нөхөр, байдаггүй ээ байдаггүй. Согтуу ч юм уу, эрүүл ч юм уу;
Амжилт, алдаа. Аль нь ч гэсэн хамаагүй, бидний л юм.;*

Хувилбар 2. Нэр бүтцийн эл хувилбарын утгын бүрэлдэхүүн нь өмнөхийг бодвол нэгдүгээр хэсэг буюу нэршсэн өгүүлбэрт өгүүлсэн юм үзэгдэл яригч хүмүүст тов тодорхой тул дахин нэрлэх хэрэггүй, зөвхөн уг юмны шинж төлөвийг тодорхойлон түүнд төрөл бүрийн байжаар үнэлгээ өгсөн утга бүхий өгүүлбэр байна. Удаах өгүүлбэр нь өмнөх өгүүлбэрийн үнэлгээг батлан тодорхойлно. Өөрөөр хэлбэл, онохуй нь энд тэг хэлбэрээр илэрнэ. Утгын цөм нь тэг хэлбэрээр илэрсэн онохуйн хэлбэр, хэмжээ, тоо ширхэг, өнгө, мөн чанар, шинж төлөв зэрэг байна. Нөгөөтэйгүүр, тийм төрлийн тодорхойлолтууд нь ярилцагч хүмүүсийн сэтгэлийн хөдлөлийг олонтаа илэрхийлдэг тул хэлний хүч нэмэгдүүлсэн хэрэглэхүүн өргөн авдаг. Дан ба харилцаа ярианы хоёр хэлбэрээр маш өргөн тааралддаг. Үүнд:

a. N! ← V

Ийм том! Яагаад ч тэвэрт багтахгүй.;
Аа, яасан том юм бэ?! Машинд багтахгүй шүү дээ.
Энэ шиг хар. Яг л замын хар гэсэн үг.;
(Цаадах чинь) нохой, нохой! Хэзээ ч үнэнээ хэлэхгүй.;
Да-а муу чөтгөр! Хүний үгэнд орно гэж бүр огт байхгүй шүү.
Энийгээ, та минь ээ, хараач! Ургаж байна, харахгүй юу!;

б. - N!
- ?
- N. (V.)

- *Мөн өндөр өө !*
- *Сайхан эд байна.*
- *Тийм байна.;*

- *Сайхан, сайхан!*
- *Юу тэр вэ?*
- *Яагаав, саяын бидний хардаг.*
- *Аа.;*

Хувилбар 3. Эл хувилбарын онохуйн хэсэг нэгдүгээр хувилбарынхтай төстэй боловч уг онохуйг онцлон ялгах олдмол шинж тэмдэг нь өгүүлэгч хүний хувьд гэнэтийн, тохиолдлын чанартай байх тул үнэлгээ шаардсан анхааруулах эсвэл асуух өгүүлбэрийн аялга, өнгө аястай байна. Хэлбэрийн хувьд онохуй нь заавал нэрлэхийн тийн ялгалд хэлбэржсэн байх албагүй. Оногдохуйн хэсэг нь гол төлөв хоёр байх нь бидний цуглуулсан баримтаас харагдаж байна. Үүний эхнийх нь утгын хувьд хариулт шаардахааргүй асуух өгүүлбэр, эсвэл төрөл бүрийн баймжийн утга бүхий өгүүлбэр, харин гурав дахь нь шалтгааныг тодруулах ерийн асуух өгүүлбэр байна. Хэлбэрийн хувьд тасалдсан буюу эзэн биегүй өгүүлбэр голддог. Үүнд:

- а. - N !
- ? (!)
- N ? (V?)

Энэ нөхрийн цамцыг ээ! Шалбааган дотор хөрвөөчихсөн юм уу ? Яачихсан юм бэ? ;

Пээх наад нүүр чинь ! Хярамцаг шиг болчихсон байна ш дээ! Яав аа?;

Энэ олон амьтныг ээ! Яг л шоргоолж шиг. Юунд энд цугласан юм бол оо!;

- б. - N !
- ?

Өө, Дорж уу. За сайн уу, сайн явж байна уу хөө. ; (Өө, Дорж.! За сайн уу, сайн явж байна уу?)

Энэ чинь танай охин уу? Мөн том болжээ! (Энэ чинь нээрэн танай охин! Мөн том болжээ!);

Нөгөө утас уу? (Нөгөө утас !) Жигтэйхэн их юм байна ш дээ.

“Б” -г дэд хувилбар болгон үзэх үндэслэл нь юуны өмнө онохуйн хэсгийн хэлбэр, утга өмнөх дэд бүтэцтэй ижил, эсвэл зарим талаараа төстөйд оршино. “Б” дэд бүтэц энгийн ярианд өмнөхийг бодвол маш өндөр давтамжтай хэрэглэгддэг байна.

Хувилбар 4. Эл хувилбарын онохуйн хэсэгт онохуйн орших орон зай заасан үйл үг оролцох бөгөөд энэ нь гол төлөв бай- туслах үйл үг эсвэл түүнтэй утгын хувьд тэнцэх үйл үг (*ажилладаг, өлгөөтэй байсан, хэвтэж байсан* г.м.) байх бөгөөд тэр нь бие, цагийн хувиллаар хэлбэржсэн байна. Бүтцийн хувьд өмнөх хувилбаруудаас ялгаатай. Өгүүлэмжийн бүрэлдүүлбэрийн эхний өгүүлбэр гол төлөв хоёр гишүүнт энгийн өгүүлбэрийн бүтэцтэй, харин удаах өгүүлбэрүүд нь нэг гишүүнт эзэн биегүй өгүүлбэр гол төлөв таарч байна. Бүдүүвчээр үзүүлбэл:

- N + V. ← V. [...] болно.

Харилцаа ярианд орох тохиолдолд дээрх үндсэн бүрэлдүүлбэрүүдээс эхний өгүүлбэр нь хоёр гишүүнт асуух өгүүлбэр болохыг эс тооцвол хэлбэр зарчмын хувьд өөрчлөгдөхгүй. Харин бүрэлдүүлбэрийн тоо нь хоёр биш, гурав голдуу байна. Асуултын хариу нь гол төлөв товч батламжилсан утгатай энгийн нэг гишүүнт өгүүлбэр байна. Гурав дахь нь нэг гишүүнт эзэн биегүй өгүүлбэр хэвээр орно. Бүдүүвчийн жишээг доор харна уу.

- N + V ?
- V. (N)
- V

Онохуйг тодорхойлсон өгүүлбэр нь:

- тухайн онохуйн шинж тэмдгийг заасан байна. Эл чанараараа нэр бүтцийн I –р хувилбар хэв шинжтэй төстэй байна. Түүнээс зөвхөн хэлбэрээрээ ялгаатай.

-Манай нутагт Дэлгэр гээд нэг өвгөн байх. За дуулна ч гэж ёстой чадна даа.;
Энд нэг залуу бий. Хүмүүс ярих нь их л мэргэн юм байх.;

- тухайн онохуйг гол төлөв орон байраар нь тодорхойлсон, онохуйн тухай асуусан өгүүлбэр байна. Үүнд:

Энд нэг хайч байсан. Хаашаа орчих воо? .
Энд нэг чөдөр, ногт хоёр өлгөөтөй байсан юмсан. Хайчиваа?
Байна уу? Өчигдөр танайд нэг шар хулдаас байсийм. Одоо байна уу?;

Нөгөөтэйгүүр, энэ болон дээр өгүүлсэн олон жишээ дан яриа төдийгүй харилцаа ярианд хэрэглэгдсэнийг бид зай хэмнэх үүднээс эвхэж оруулснаа энд зориуд тэмдэглэе. Үлгэрлэвэл:

- Өчигдөр танайхаар нэг нөхөр ороод гарч байгаа харагдсан.
 - Ямар? Хар күртиктэй юу?
 - Тийм, цахилгаанч уу, слесарь уу?
- (Өчигдөр танайхаар нэг нөхөр ороод гарч байгаа харагдсан. Цахилгаанч уу, слесарь уу гэх мэт.)

- уг онохуйн тухай бусад мэдээлэл. Үүнд:

Бидний ард нэг ах явсан даа, чи санаж байна уу? Чамайг таньдаг гэж байна лээ ш дээ.;

Миний хажууд надтай хамт нэг залуу ажилладаг юм. Өчигдөр тэгсэн чинь мань хүн байдаггүй, ирдэггүй. Сурахнаан чинь ажлаасаа гарчихсан гэдэг байгаа;

Дээрх хувилбарууд гол төлөв дан ярианд тааралдах боловч харилцаа ярианд тааралдахгүй гэж үзэж болохгүй.

- Манай ангийн Дулмаа, яагаав ? Бүдүүн, бор.
- Аа тийн.
- Өчигдөр над дээр ирсэн. Чамайг бас асууж байна лээ.;

Хувилбар 5. Нэр бүтцийн эхний хэсэг нь бүрэлдүүлбэрийн хувьд өмнөх хувилбарынхтай (1, 4) зарим талаараа ижил, төстэй байна. Гэвч энд онохуй нь зөвхөн асуух өгүүлбэрийн онохуй байна. Хоёрдугаар хэсэг буюу асуултын хариулт нь мөн өөрийн өвөрмөц хувилбар загвартай. Эл бүтэц зөвхөн харилцаа ярианд таарна.

- Энд нэг “Гутал засвар” байгаа гэсэн юм. Хаана байна?
- - Өө, тэр, онгорхой хаалга. ;
- Дорж энд байна уу?
- Явчихсан, гэрээдээ.;

Хувилбар 6.. Хүмүүний аливаа үйлд үнэлгээ өгсөн өгүүлэмжид үйлийг нэрлэсэн нэр бүтэц онохуйн үүргийг гүйцэтгэх нь монгол ярианд цөөнгүй таардаг. Бүтцийг нь бүдүүвчээр үзүүлбэл:

$$N + V. \leftarrow V.$$

Явна, явна л гэнэ. Яамай л байгаа даа.;

Мөнгө, мөнгө л гэх юм. Хэзээ ч хэрэг болох юм билээ дээ.

Хувилбар 7. Энд монгол ярианд маш өргөн хэрэглэгддэг нэрийн шилжсэн утгаар илэрсэн олон бүтцийг оруулж байна. Энэ нь хэлбэрийн хувьд бүдүүвчээрээ хувилбар 1-2а-тай ижил хэдий ч утгаараа зөвхөн өвөрмөц онцлогтой.

"Их дэлгүүр" (буудал), энд буух нь зөв үү?;

3-4-р хороолол (явах хүмүүс), суугаарай;

Дархан, хэдэн төгрөг вэ? (тасалбарын үнэ);

Өгүүлэмжийн хүрээнд онохуйн үүрэг хүлээсэн нэр бүтцийн олон хувилбар бүрэлдүүлбэр-өгүүлбэрийн дэлгэрэнгүй ба дэлгэрэнгүй бус бүрэлдэхүүн, үйл үгийн оролцоо, нэр үгийн түүнд захирагдсан хэв шинж, аялга, зогсоц зэрэг авиазүйн үзэгдлээс гадна асуух хийгээд хүч нэмэгдүүлсэн сул үг, туслах үг, төрөл бүрийн баймжийн илэрхийлэлүүд зэрэг нь онох, оногдохуйн хэсгийг тусгаарлах, түүнийг бие даасан шинжтэй болгоход чухал үүрэгтэй болох нь дээр өгүүлснээс харагдаж байна. Энэ тухай энд эс өгүүлэн, оногдохуйн байршилд хэрэглэгдсэн нэр бүтцийн хувилбаруудыг үргэлжлүүлэн авч үзье.

Б. Оногдохуйн (S) үүргээр хэрэглэгдсэн нэр бүтцийн бүлэг хувилбар

Нэр бүтцийн эл бүлэг хувилбар дараахь давхар өвөрмөц онцлогтой. Үүнд:

- 1) Нэр бүтэц бүхэлдээ байршил хийгээд бүтцээсээ үл шалтгаалан оногдохуйн үүргээр хэрэглэгдэнэ. Жишээ нь: Алив дээ. *Цаана чинь ширээн дээр миний малгай байгаа. Цаана чинь ширээн дээр миний малгай байгаа.* Аваад өгдөө!
- 2) Нэр бүтцийг утгын хувьд захирсан үйл үгийн хэлбэр нь зөвхөн тэг хэлбэрээр илэрнэ. Дээрх жишээг харна уу. Утгын хувьд оногдохуй нь уг өгүүлбэрт аль нэгэн байдлаар, жишээлбэл, төлөөлөх хэрэглэхүүнээр илрэхгүй.
- 3) Нэр бүтцийн бүрэлдэхүүнд төлөөний нэрийн зохицол байхгүй. Түүнээс бусад онохуйн үүргээр оролцсон нэр бүтцийн (дэлгэрэнгүй-дэлгэрэнгүй бус, нэр бүтцийн бүрэлдэхүүнд үйл үг оролцсон эсэх г. м.) өмнө тэмдэглэсэн шинж чанар энд мөн давтагдана.

Нөгөөтэйгүүр, эл хийгээд өмнөх бүлгийг нэр бүтцэд хамруулан үзсэн үндэслэлийг тодорхой өгүүлэмжид тухайн өгүүлбэр бүхэлдээ утгын хувьд онохуй хийгээд оногдохуйн үүргийг гүйцэтгэж байгаа, эсэхийг бид зөвхөн утгазүйн үүднээс болзмол чанараар нь тодорхойлсон болно. Хэрэв нэгдүгээр бүлгийн хувилбаруудад нэр бүтцээр илэрсэн өгүүлбэр нь мэдээллийн уламжлалт онолоор гол төлөв суурь (хуучин)

мэдээлэлтэй холбоо бүхий үйлийн эзэн байсан бол эл бүлэг хувилбаруудад тэр нь тулгар мэдээлэл (шинэ) буюу өгүүлэмжийн утгын цөм болсон үйлийн тусгал болж байна. Энэ нь өгүүлэмжийн бүрэлдүүлбэр-өгүүлбэр өөр хоорондоо хэлзүй хийгээд утгазүйн хувьд дотоод нягт нэгдэлтэй болохыг эргэлзээ төрүүлэхээргүй илэрхийлж байна. Одоо оногдохуйн үүргээр хэрэглэгддэг бүтцүүдийг хувилбар бүрээр нь авч үзье. Үүнд:

Хувилбар 1. Нэр бүтэц орсон өгүүлэмжийн эхний өгүүлбэр нь асуух өгүүлбэр байх бөгөөд хариулт, асуулт хоёр өөр хоорондоо зөвхөн утгын холбоотой энгийн өгүүлбэрийн төрлүүд байна. Харин тэдгээрийн хооронд бүтэц хийгээд хэлбэрийн хувьд аль нэг хамаарал байхгүй. Өгүүлэмжийг бүрэлдүүлсэн өгүүлбэрүүд бүхэлдээ хэл ярианы нөхцөлөөс үүдэн хэд хэдэн загвараар илэрч байна. Одоо дэд хувилбар бүрээр нь нарийвчлан авч үзье. Нэгдүгээр асуух өгүүлбэр нь эзэн биетэй\ эзэн биегүй энгийн өгүүлбэрийн хэлбэрээр илрэх хоёр тохиолдолд нэр бүтцээр илэрсэн өгүүлбэр нь мөн хоёр янзаар илэрсэн жишээ бидний санд байгаа өгүүлэмжийн дийлэнх хэсгийг эзэлж байна. Үүнд.

1. а. - N + V?
- N+V.

- *Чи үүнийг хаанаас авав аа?*
- *Манай хажууд хувийн нэг дэлгүүр шинээр нээгдсэн юм.*
- *Аятайхан юм байна;*

- *Хэн энэ тухай чамд хэлэв ээ?*
- *Өчигдөр Доржоос захиа ирсэн юм.;*

- *Хаах, чи чинь үүнийг юугаар гялалзуулчих вaa?*
- *Тусгай зүлгүүр байдаг юм.*

- б. - N ?
- N (V).

- *Хаанаа?*
- *Манай цаад талын цэнхэр хаалга.;*
- *Ямарыг нь?*
- *Тэ - эр том хөх номны цаад талд байгаа, хүүхдийн зурагтайгаас нь.;*
- *Хэдийд юм?*
- *Сайн мэдэхгүй, маргааш үдээс хойш гэж энэ хүмүүс л ярьж байна.;*

- в. - N + V?
- N.

- *"Гутал" хаанаа?*

- *Хоёр давхарт. ;*
- *" Их дэлгүүр " хол уу?*
- *Үгэй, дараагийн буудал.*

Эл хувилбарын асуух өгүүлбэр нь заавал хариу шаардахааргүй, дан ярианд орсон байж болно. Энэ хэв шинж монгол ярианд мөн түгээмэл хэлбэр. Энэ нь, нөгөөтэйгүүр яриа хөгжүүлэх, уг юманд хүч нэмэгдүүлэх нэгэн хэрэглүүр болдог байна. Доор өгсөн жишээг өмнөх бүтэц, жишээтэй харьцуулан үзнэ үү.

Наад найз чинь хаана буудаг гээч. "Чингэс" буудал, одоо мэдэв үү?;
Над юу гэж хэлсэн гээч. Бүр гомдмоор. Эндээс зайл гэж байгаа юм даа;

Өгүүлэмжийн дээрх гурван дэд хувилбар бүрт эхний өгүүлбэр нь асуух өгүүлбэр байсан бол дараах дэд хувилбарт хэлбэрийн хувьд тэр нь аливааг баталсан эсвэл үгүйсгэсэн утгатай өгүүлбэр орно. Харин хоёрдугаар өгүүлбэр нь эхний өгүүлбэрийн утгын аль нэг хэсгийг тодотгосон, лавлан асуусан өгүүлбэр байна. Эл дэд хувилбар өмнөхийг бодвол харьцангуй бага идэвхтэй. Бүдүүвчээр загварчилбал:

- 2.
- N + V.
 - N?
 - N+V.

- *Тэр чинь манай Хяналтын хэлтэст ажиллаж байсан юм.*
- *Ямар аа?*
- *Аа, манайд Хяналтын хэлтэс гэж хуучин байсан юм.;*

Оногдохуйн үүргээр орсон нэр бүтцийг агуулсан дээрх өгүүлэмжүүд нь монгол энгийн ярианд маш түгээмэл хэрэглэгддэг. Өөр нэг онцлог нь дээрх хувилбар зөвхөн харилцаа ярианд тааралдаж байна.

Хувилбар 2. Нэр бүтцээр илэрсэн өгүүлбэр тодорхой өгүүлэмжийн хүрээнд биеэ даасан, гол төлөв хоёр бүрэлдэхүүнтэй, орон зайн утга илэрхийлэсэн байна. Эл загвар монгол энгийн ярианы хамгийн түгээмэл бүтцийн нэг болой. Уг өгүүлбэрийн бүрэлдэхүүнд *ийм, тийм, энэ (-эн) шиг, тэр(-эн) шиг, энд, тэнд, цаана чинь, наана чинь, шиг* гэх мэт төлөөний нэр, дайвар үг болон туслах үг өргөн хэрэглэгддэг. Нэр бүтцийн эл хувилбарын өөр нэгэн онцлог нь өгүүлэмжийн бүрэлдэхүүнд бүхэлдээ шууд тусагдахууны үүрэг гүйцэтгэдэгт оршино. Нэр бүтцийн тусгалыг нь хүлээсэн нөгөө өгүүлбэрийн үйл үг нь гол төлөв хоёрдугаар биед хандсан захирах, тушаах хэлбэрээр хэлбэржсэн байна. Өгүүлбэр нь бүрэлдэхүүний хувьд эзэн биегүй энгийн өгүүлбэр зонхилно. Өмнөх хувилбарыг бодвол эл хувилбар дан ярианд зөвхөн хэрэглэгдэнэ. Өгүүлэмжийн эзэн биегүй үйл үгээр өгүүлэхүүн нь илэрсэн өгүүлбэрийн байршил хийгээд хэлбэрийн утгаас нь шалтгаалан энд хэд хэдэн дэд төрөл ялгах боломж байна. Үүнд :

1. a. V! ← N + V.

Алив, өг дөө ! Цаана чинь миний сурах бичиг ширээн дээр байгаа.;
Алив дээ! Тэ-эр цаана чинь нэг малгай байгаа;
Шалгачих! Цаад өрөөнд чинь юу байна.
Хүүе, алаадахаарай! Цаана чинь нэг ялаа явна.;

б. N + V. ← V! [...]

Миний ном гэрт, шүүгээн дээр байгаа. Гялс аваад ир!;
Наана чинь бас нэг шуудай байна, аваад яв. Одоо над хэрэггүй.;
Тэр орны дор байна! Түргэл, түргэл, бахь, бахь;
Тэр сандал дээр байна цамц, алив аваад өг! ;

Энэхүү дэд хувилбарын өөр нэг хэв шинж нь үйлийн хэлбэр нь гурав дахь биед хоёрдогч хүнээр дамжуулан хандсан энгийн ярианы олон тооны түгээмэл бүтэц болно. Доорх жишээг өмнөх бүтцийн бүдүүвч болон түүнийг илэрхийлсэн жишээтэй дүйлгэж үзнэ үү.

Цаана чинь нэг эмэгтэй байгаа. Ор гэж хэл дээ.;
Өндөр нуруутай, цагаан үстэй хүн байгаа. Май, үүнийг өгчихөөрөй;
Яг та нарын зам дээр. Хужирт руу эргэдэг зөрлөг дээр Дорж гэж нэг хөгшинийх байгаа. Үүнийг өгчихөөрөй, хүү чинь мөд очно гээрий.

Дээрх хоёр дэд хувилбар нь өгүүлэмжийн эзэн биегүй, гол өгүүлбэр нь үйл үгээр илэрсэн өгүүлбэрийн байршлаар зөвхөн ялгаатай байна. Харин өгүүлэмжийн бүрэлдэхүүн өгүүлбэрийн хооронд тус бүрийг анхаарлын тэмдэг, таслал тавьж үргэлжлүүлэн бичих зэргээс хувилбар зарчмын хувьд өөрчлөгдөхгүй. Учир нь аль ч тохиолдолд утга гүйцэлдүүлсэн зогсоц энд маргаангүй хэрэглэгдэнэ. Дэд хувилбарууд (1а б) өгүүлэмжийн эзэн биегүй үйл үгээр өгүүлэхүүн нь илэрсэн өгүүлбэрийн байршлаас үүдэлтэй бол дараагийн дэд хувилбарт өгүүлэхүүний утга нь захирах биш зөвхөн зөвшөөрөл хүссэн утгатай байна. Харин өмнөхтэй ижил байршлын хувилбар гарахгүй. Нэр бүтцээр илэрсэн өгүүлбэр өгүүлэмжийн эхэнд гол төлөв хэрэглэгдэнэ. Цөөн тохиолдолд байрлал урвуу байж болно. Ингэхэд өгүүлбэрийн бүтцэд зарим өөрчлөлт гарч болно.

2. a. N + V. → V?

Ийм хэдэн янгиа байна. Авах уу? ;
Дөнгөж сая хэдэн авдар ирлээ. Ачих уу, дарга аа?;
Сая нэг хэдэн боодол сонин ирлээ, явуулах уу?;
Энэ хойт уулаар дүүрэн гөрөөс. Маргааш мордох юм биш үү. ;
Манай энд намартаа мөөг гэж ёстой шороо, манайхаар дахиад ирээрэй.

б. $N + V? (V?) \leftarrow N + V.$

Чи өгчих дөө? Ийм юм чамд зөндөө л байгаа ш дээ. ;

Чамд өгөх үү, нэг ийм юм байна. ;

Чи авах уу, энэ шиг юм над байж л байна. ;

Аав аа, авах уу, энд нэг ийм дугуй байна. ;

в. Би хэвтүүртээдэхье л дээ. Манай тэнд нэг хувийн элнэлэг байгаа. ;

Алив боогоод огье, энд нэг том цаас байсан юм сан. ;

Дээрх гурван хувилбарт өгүүлэмжийн үйл үгээр өгүүлэхүүн нь илэрсэн өгүүлбэр нь захирах, тушаах, гүйх, хүсэх утгатай байсан бол одоо авч үзэх гуравдугаар хувилбарт үйл үг нь аливааг зөвхөн нотлох үүрэгтэй хэрэглэгдсэн байна.

3. $N + V. \leftarrow V.$

Охидууд аа, энд миний цунх байсан юм. Туучихжээ.

Доржийнх хэдэн малтай л айл байсан юм. Энэ хүү нь дуусгав бололтой.

Хувилбар 3. Монгол энгийн аман ярианд түгээмэл “V + нь”, “V + минь”, “V + нь + тэр”, V+ энэ үү? зэрэг хувилбар бүтцийг нэр бүтцийн бүрэлдэхүүнд хамруулан үзэх нь зүйд нийцнэ. Учир нь дээрх зүүлтүүд нь эл бүтцэд хамаатуулах болоод заах төлөөний нэрийнхээ утга илэрхийлэх үүргээсээ зарим талаар хөндийрч өмнөө орж нийлэмж бүтээсэн үйл үгээ нэршүүлэх үүрэг хүлээдэг. Бичгийн хэлбэрээр эл хэв шинжит бүтэц илрэх нь тун ховор. Харин энгийн ярианд хэрэглэгдэх байдал нь өвөрмөц шинжтэй бөгөөд бидний ажигласнаар цөөнгүй хувилбартай. Одоо хувилбар бүрийг эхлээд жишээгээр харуулъя. Үүнд:

V нь (минь, чинь, тэр г.м.) $\leftarrow V. (N+V.) [...]$

- 1) Тэвчишгүй нь (ээ). Нэг юм бодоцгооё:
Очих минь. Та нар намайг яагаад ч хорьж чадахгүй;
(Хариад л суулаа.) Тэгсэн чинь ер нь болохгүй нь. Би ч хэллээ... ;
(Мань хүн суугаад л байна.) Явахгүй нь ээ. Би хий л босох юм, суух л юм. ;
- 2) Нөгөө авна, авна гэсэн нь энэ (тэр) үү? Мөн ч авлаа даа.
Ирнэ гээд байсан нь энэ үү? Ёстой ирлээ дээ!
- 3) Гялс гээд ороод ирэх тэр. Би яах вэ лээ. Хий л бослоо.
Пар гээд машин гэрийн гадаа ороод ирэх тэр. Би яах вэ дээ. Сууж л байлаа.

Утгын хувьд дээрх жишээнээс харвал үйлийн нэршсэн бүтэц нь тодорхой онохуйн нөхцөл байдал, үйл хөдлөл зэргийг илэрхийлж тэр нь цааш гүйцэтгэх үйлийн учир шалтгаан болсон нь нэлээд түгээмэл байна. Онохуй нь нийт жишээнд тэг

хэлбэрээр илэрнэ. Харин жишээ 2-т оногдохуйн хэсэг нь үнэлэмж илэрхийлсэн байна. “V нь” бүтцийн бүрэлдэхүүнд утгыг гүйцэлдүүлсэн “энэ” угтаа хэрэглэгдэх учиртай мэт санагдана. Эл үг нь уг загварын хүүрнэсэн өгүүлбэрийн бүтцэд өмнө нь орсон гуравдугаар биеийн хамаатуулахын “нь” -тэй нийлж түүнд уусан хэлэгдэж байж болох талтай. Учир нь эл өгүүлбэрийн загвар асуух ба анхааруулсан өгүүлбэрийн загварт шилжин хэрэглэгдэхэд дээрх “энэ” урган гарч ирж байна. Жишээ 2-ыг үзнэ үү.

Харин “тэр” төлөөний нэр бол дуудлагын хувьд “нь” -ээс гойд ялгаатай тул уусч хэлэгдэхгүй байна гэж үзэж болно. Туслах үг “ээ”-гийн тухайд бол түүний хэрэглэгдэх эсэх нь өгүүлэгч этгээдийн илэрхийлж байгаа санааны давхар өнгө аяс буюу баймжаас шалтгаална. Тэгтэл, нөгөөтэйгүүр “энэ” заах төлөөний нэр уг бүтцэд өмнөх “нь”-тэй уусан дуудагдахгүй бас тохиолдол байж болно. Түүнийг өмнөхөөс ялгаатай үзэх хэрэгтэй. Тухайлбал, өдөр тутмын сонин хэвлэл, мэдээллийн бусад хэрэглүүрт эл бүтцийн загвараар гэрэл зураг болон бусад дүрсэлсэн үзмэрийн тайлбар хийсэн байх нь (*Төлөөлөгчдийн угтаж авч байгаа нь* гэх мэт) цөөнгүй таардаг. Эл тохиолдолд заах төлөөний нэр “энэ”, “тэр”-ийг уг зураг, үзмэр төлөөлж байна гэж үзэх хэрэгтэй. Энэ тухай бидний өгүүллээс дэлгэрэнгүй үзнэ үү. Өөрөөр хэлбэл, эл тохиолдолд уг зураг, үзмэр нэг ёсондоо логикийн буюу учир шалтгааны оногдохуйн үүргийг, хэлзүйн үүднээс гэвэл нэгэн төрлийн өгүүлэхүүний үүргийг гүйцэтгэж байна гэж үзэхээс өөр аргагүй. Эл хоёр загвар нь хэдийвээр хэлбэрийн хувьд төрөл, нэг сурвалжаас үүдэлтэй боловч тус тусдаа “чулуужиж” тогтмолжсон загвар юм. Эхнийхэд нь үйлт нэрийн ирээдүй цагийн -х -гээр илэрсэн хэлбэр нь хэл ярианы дээрх нөхцөлд үйлийн болсон хийгээд болж байгаа байдлаас үл хамааран, өөрчлөгдөхгүй. Жишээг эгэн үзнэ үү. Нөгөө хоёр дахь төрөл загварт зэрэгцсэн нөхцөл үйлийн “-ж + байгаа нь” дээрх хэл ярианы уг нөхцөлд мөн “чулуужиж” одоо цагийн хэлбэрээс өөр хэлбэрт хэрэглэгдэхгүй болсон байна.

“V нь”, (энэ, тэр) загвар гол төлөв хүүрнэсэн, анхааруулсан, асуусан өгүүлбэрт ижилхэн өргөн давтамжтай хэрэглэгддэг бол түүний бусад хувилбар (V чинь + яасан?, V чинь +алив (дээ)?, V чинь +хаа байна?, V чинь +яагаав? гэх мэт) гол төлөв асуух өгүүлбэрт тааралдаж байна. Хэлэх байдал, тодорхой зорилгоос шалтгаалан эл бүтэц нь нэг эсвэл хоёр бие даасан өгүүлбэр болох нь ховоргүй.

Чиний нөгөө наймд ирнэ гэсэн чинь яасанб?;

Чиний нөгөө наймд ирнэ гэсэн чинь. Яасанб? ; .

Авч байна, авч байна гэсэн. Алив дээ?;

Авч байна, авч байна гэсэн чинь алив дээ?;

Байдлаас ажихад, нэгдүгээр биеийн хамаатуулахын “минь” ч нэр бүтцэд цөөнгүй хэрэглэгддэг болох нь харагдаж байна. Гэхдээ энд бас тэр нь өөрийн өвөрмөц онцлогтой:

Орой болчихлоо. Одоо явах минь. ;

Хонь ирлээ. Саалиндаа гарах минь;

- Ээж ээ, манай үхэр гараад ирлээ.

- Өө тэгэв үү. Тугалаа уях минь; гэх мэт.

“V минь” загвар орчин цагийн аман ярианд дээрх хувилбаруудаа бодвол харьцангуй бага хэрэглэгддэг байж болно.

Хувилбар 4. Эл хувилбарын өвөрмөц онцлог нь нэр бүтцийн хоёр хэсгийн нэг нь нөгөө хэсгийн утгыг хумин зангидсан байхад нөгөө нь задлан тоочсон байна. Тоочсон хэсэг нь хэд ч байж болно. Утгын зангилаа хэсэг нь тоочсон хэсгийн урд ба хойно нь хаана ч байж болно. Зангилаа хэсэг нь нэр бүтцээр илэрнэ.

$N + V, N + V, [...]$

- *Би чинь энэ хэдэн хүүхдийг хувицаслана, хоолтуулна. Бас цаана нь манай нөхрийн аав ээж байгаа. Хэцүү шүү хэцүү.; (- Хэцүү шүү хэцүү. Би чинь энэ хэдэн хүүхдийг хувицаслана, хоолтуулна. Бас цаана нь манай нөхрийн аав ээж байгаа.)*
- *Яахав, болж л байна. Саяхан хүү минь хэдэн төгрөг хүнээр явуулсан байна лээ. Охин чиг бас ирээд хэд хоноод явсан.; (Саяхан хүү минь хэдэн төгрөг хүнээр явуулсан байна лээ. Охин чиг бас ирээд хэд хоноод явсан. Яахав, болж л байна.)*

Онохын байршилд хэрэглэгдэж байгаа нэр бүтцийн дээр өгүүлсэн хувилбарууд нь бидний хураасан бүтцийн санд хамгийн өндөр давтамжтай байв.

Хувилбар 5. Өгүүлэмжийн эхний өгүүлбэр нь өмнөх хувилбар 1-ийн ижил хоёрдугаар биед хандсан захирах, тушаах, гуйх, хүсэх зэрэг утга илэрхийлсэн үйл үгээр илэрсэн өгүүлэхүүн бүхий өгүүлбэр байна. Нэрийн бүтэц бүхий өгүүлбэр нь түүнийг утгын хувьд дагалдсан нэмэлт нэрийн бүлэг эсхүл зөвхөн утгын холбоо бүхий ерийн өгүүлбэр орсон байж болно.

$V! \leftarrow N, (N + V)$

Энэ хажуу талын ТҮЦ-нээс нэг гоймон аваад ир! Өө бас хэдэн төмс, хэрэв байвал.;

Май, үүнийг Дулмаа гуайд аваачаад өг. Бас энэ бидааныг. Эртүүд би аваад ирсэн юм.;

Доржийг дуудаж байна гээ. Бас Дулмаад хэлээрэй.;

Цаадулдаа хэл хүргэ. Доодоогийнх саахалт гэнэ лээ шүү бас.

Нийтдээ оногдохуйн байршилд хэрэглэгдэж байгаа нэр бүтцийн хувилбар хэдийвээр хэрэглэгдэх хүрээгээрээ нөгөө бүлэг хувилбаруудаас дутахааргүй өргөн дэлгэр боловч бүтэц бүрэлдэхүүн, төрөл зүйлийн хувьд тийм ч олон янз биш бололтой.

* * *

Өгүүлэмж буюу дискурсын хүрээн дэх онохуй хийгээд оногдохуйн үүрэг хүлээсэн нэр бүтэц нь монгол ярианы хэлбэр-утгазүйн нэн чухал өвөрмөц онцлог мөн. Тэрхүү гурван бүлэг (Энд бид холимог бүтцийг оролцуулан хэлэв.) бүтэц, тэдгээрийн цөөнгүй хувилбарууд нь хэл яриа бүтэх сэтгэцийн үйл, санаагаа илэрхийлэх монгол хүмүүний уламжлалын шууд үр дагавар буюу бодот илэрхийлэл нь болно. Нөгөөтэйгүүр, дээрх өвөрмөц онцлог нь аман яриаг бичгийн хэлбэртэй нь таацуулан үзвэл харилцагч хүн өгүүлэх санаагаа өмнөөс бэлддэггүй, шууд илэрхийлэх шаардлагатай, ярилцаж байгаа юм, үзэгдэл нь харилцагч хүмүүсийн дэргэд нь байдаг, эргэн тойронд нь болдог, тэрбээр харилцагч хүнтэйгээ гол төлөв зайнаас биш нүүр тулан мэдээлэл солилцох орчин нөхцөлтэй зэрэг нь хэлний бус хэрэглэхүүн (янз бүрийн дохио, зангаа гэх мэт) ашиглах, зарим зүйлийг заавал нэрлэх, тайлбарлах шаардлага гардаггүй зэргээс улбаалан бүрэлдсэн байна.